



БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМ



**Монгол Улс: Дээд боловсролын шинэчлэл
төсөл**

АХБ Төслийн дугаар. 43007-023

Төслийн код: ДБШТ МОН Зээлийн дугаар. 2766

“Дээд боловсролын шинэчлэл” зөвлөх үйлчилгээ

МОНГОЛЫН ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ДУНД ЭРЭМБЭ, ЧАНСАА ТОГТООХ АРГА ЗҮЙ ЗӨВЛӨМЖ

Их сургуулийн засаглалын зөвлөх баг

Доктор Питер Саймон Хорн, Ph.D.,
LL.M. Багын ахлагч

Доктор Ж.Сүхбаатар,
Ph.D. Багын дэд
ахлагч



PT.TRANS INTRA ASIA

**2016 оны 11 сар
Улаанбаатар хот**



МОНГОЛЫН ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ДУНД ЭРЭМБЭ, ЧАНСАА ТОГТООХ АРГА ЗҮЙ

Оршил

Дээд боловсролын шинэчлэлийн төслийн олон улсын зөвлөх үйлчилгээний их сургуулийн засаглалын зөвлөхүүдийн ажлын удирдамжинд олон улсын шилдэг тэргүүний туршлагыг харгалзан Монголын дээд боловсролын сургалтын байгууллагуудыг эрэмбэлэх системийг санал болгох тухай тусгагдсан юм. Энэхүү удирдамжийг хэрэгжүүлэхийн тулд засаглалын асуудал хариуцсан дотоодын зөвлөхийн зүгээс дараах үйл ажиллагааг авч хэрэгжүүлсэн болно. Үүнд:

1. Их сургуулийн эрэмбэ тогтоох хамгийн түгээмэл хэрэглэгдэж буй томоохон системүүдийг судаллаа.
2. Их сургуулийн эрэмбэ тогтоох олон улсын системд хамрагдахад Монголын их дээд сургуулиудад тохиолдож буй бэрхшээлт асуудлуудыг тодорхойлов.
3. QS-ийн эрэмбэ тогтоох системийн мэргэжилтнүүдтэй холбоо тогтоож Монголд хэрэгжүүлж болох эрэмбэ болон чансаа тогтоох системийн талаар санал солилцлов.
4. QS Од үнэлгээний аргачлалыг орчуулж Монголын дээд боловсролын байгууллагуудад туршилтийн журмаар үнэлгээ хийх бэлтгэл хангав.
5. 20 гаруй их сургуулиас судалгаа авч дүн шинжилгээ хийж аргачлалыг Монголын нөхцөлд нийцүүлэн боловсронгуй болгов.
6. Эрэмбэ тогтоох болон чансаа тогтоох арга зүйн асуудлаар их, дээд сургуулиудад танилцуулж тэдний саналыг авлаа.

Эдгээр ажлын үр дүнд санал болгож буй системийг боловсруулсан болно.

Дээд боловсролын байгууллагуудад эрэмбэ /Ranking/ юм үү чансаа /Rating/ тогтоох асуудал нь өнөө үед ихээхэн ач холбогдолтой болж байна. Үүнийг дараах хоёр зүйлээр тайлбарлаж болох юм.

Нэгдүгээрт, Монгол Улсын Их Хурлын 2015 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-ын 7.13.-д 2024 он гэхэд Монгол Улсын дөрвөөс доошгүй их сургуулийг Азийн шилдэг 100 их сургуулийн эгнээнд хүргэсэн байна гэж заасан байна. Үүнтэй холбоотойгоор их сургуулиуд Азийн их сургуулиудын эрэмбэ тогтооход хамрагдахыг эрэмлээх хэрэгтэй болж байна.

Хоёрдугаарт, 2016 оны 4 сард Их Хурлаар Дээд боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг баталлаа. Энэ хуулинд шинээр орсон нэг заалт нь магадлан итгэмжлэлийн байгууллагын эрх үүргийг өргөтгөж урьд нь БСШУЯ-ны гүйцэтгэж байсан зарим үүргийг БМИҮЗ-д шилжүүлсэн явдал юм. БМИҮЗ нь 2015 онд магадлан итгэмжлэлийн шалгуур, стандартуудаа шинэчлэн боловсруулсаны дотор тухайн байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлт болгож үндэсний болон олон улсын эрэмбэлэл, чансаа тогтоох системийн дагуу тухайн сургуулийн эзэлж буй байр суурийг авч үзэх боллоо. Ийм нөхцөлд төрийн өмчийн болон хувийн хэвшлийн аль ч их дээд сургуулиуд эрэмбэ, чансаа тогтоох тогтолцоонд хамрагдаж тодорхой байр суурь эзлэх, улмаар байр сууриа бэхжүүлэх, урагшлуулах талаар хүчин чармайлт гаргах хэрэгтэй болж байна.


Товчоор хэлэхэд төрөөс боловсролын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Монголын их сургуулиудын нэр хүнд, өрсөлдөх чадварын өнөөгийн түвшинг тодорхойлох, цаашид Азийн болон дэлхийн нэр хүндтэй их дээд сургуулиудын эгнээнд хүрч болох боломж нөөцийг

тогтоох, их сургуулиуд өөрсдөө болон хөндлөнгийн байгууллагаар рейтинг, чансаа тогтоолгох нэгдсэн арга аргачлалыг бий болгох энэхүү ажлын үнэ цэнэ оршиж байгаа болно.

Их сургуулийн эрэмбэ тогтооход хамгийн түгээмэл хэрэглэгдэж буй томоохон системүүдийн тухай

Зураг 1-д их сургуулийн эрэмбэ тогтооход хэрэглэгдэж байгаа гол системүүд, тэдгээрийг хэрэглэж байгаа улс орнуудын тухай мэдээллийг харуулав.

Зураг 1 Их сургуулийн эрэмбэ тогтоох системүүд



Дэлхийн Дээд боловсролын сургалтын байгууллагууд нь өөрсдийн эрэмбэ болон чансааг тодорхойлохдоо ихэвчлэн хөндлөнгийн, гуравдагч байгууллагуудаар тогтоолгон ирсэн. Даяарчлалыг үйл явцыг даган нэр хүндтэй олон улсын их сургуулиуд суралцах эрэлт хүсэлт нэмэгдсэнээр тэдгээр сургуулийн нэр хүнд сургалтын чанарыг дүгнэж эрэмбэ, чансаа тогтоох шаардлага гарсан байна. Олон оронд их сургуулийн эрэмбэ тогтоох тогтолцоо бүрдэж амжилттай ажиллаж байгаагаас хамгийн түгээмэл, нэр хүндтэй системүүдийг дурьдвал “Times Higher Education”, “Quacquarelli Symond”, “U.S. News & World report”, “Shanghai ARWU” зэрэг болно. Нэр хүндтэй их сургуулиуд эдгээр системд багтаж эрэмбээ тодорхойлуулахыг эрэмлээж байна. Эдгээр системүүдийн талаар товч өгүүлье.

“THE” - “Times Higher Education” “Таймс Дээд Боловсрол”

Энэхүү систем нь 2004 оноос эхлэн олон улсын түвшинд ДБСБ-ийн эрэмбэлэлийг тогтоон ирсэн бөгөөд 2004-2009 оны хооронд “Кью ЭС” эрэмбэлэлийн системтэй хамтран ДБСБ-уудын эрэмбэлэл гаргадаг байсан. Англи улсад бий болсон систем. Тус систем нь 2010 оноос эхлэн “Thomson

Reuters”-той хамтарч шинэ эрэмбэлэлийн системийг үүсгэсэн. Эрэмбэлэлийн системийн аргачлалыг гаргаж ирэхдээ 250 хуудас бүхий санал асуулгыг Дэлхийн бүх хэсгээс 50 гаруй томоохон нөлөө бүхий хүмүүс болон 300 гаруй интернет санал асуулгыг стандарт дата мэдээллийн харьцуулалт “Z-scores”-ийг ашиглан тооцоолсон. Шинэ аргачлалын дагуу ДБСБ-уудыг эрэмбэлэхдээ дараах таван ерөнхий шалгуур үзүүлэлтээр үнэлдэг.

Хүснэгт 1: Таймс Дээд Боловсролын Үзүүлэлтүүд

Ерөнхий үзүүлэлт	Тус бүрийн шалгуур үзүүлэлт	Үнэлэмж
Сургалт- сургалтын орчин /30%/	• Нэр хүндийн судалгаа (сургалт)	15%
	• Хөтөлбөр бүрийн Ph.D зэрэгтэй багш	6%
	• Хөтөлбөр бүрийн бакалаврийн элсэлт	4.5%
	• Хөтөлбөр бүрийн орлого	2.25%
	• Ph.D/Бакалаврийн зэрэг олголт	2.25%
Судалгааны - хэмжээ, орлого, нэр хүнд /30%/	• Нэр хүндийн судалгаа (судалгаа)	19.5%
	• Судалгааны орлого (оноо)	5.25%
	• Судалгааны болон багш нарын судалгааны тоо	4.5%
	• Олон нийтийн судалгааны орлого / нийт эрдэм шинжилгээний орлого	0.75%
Ишлэлүүд /32.5%/- Судалгааны нөлөө	• Ишлэлийн нөлөө (Судалгаа бүрийн дундаж ишлэл)	32.5%
Үйлдвэрлэлийн орлого /2.5%/ - инновацийн	• Салбарын судалгааны орлого (Багш түс бүрээр)	2.5%
Олон улсын төлөв байдал /5%/	• Дотоодын болон гадаадын багш нарын тооны харьцаа	3%
	• Дотоодын болон гадаадын оюутны нарын тооны харьцаа	2%

Дээрх хүснэгтээс харахад тухайн сургууль болон бусад байгууллагаас гарган авч болох бодит тоо мэдээллийг ашиглахаас гадна тухайн сургуулийн сургалт болон судалгааны нэр хүндийн талаар авах олон улсын онлайн судалгааны үр дүнг ашиглаж байна. Ийм нэр хүндийн судалгаагаар гаргаж авсан мэдээлэл тухайн нэг сургуулийн авах нийт онооны 34.5%-ийг эзэлж байна.

“QS World University Ranking” – “Кью Эс Дэлхийн их сургуулийн эрэмбэ”

“Кью Эс” нь 1990 онд анх байгуулагдсан, дээд боловсролын салбарын мэдээлэл, судалгаа шинжилгээний талаар тэргүүлэх байр суурь эзэлдэг компани юм. Хэрэглэгчид, бодлогын шийдвэр гаргагчдад зориулан олон улсын хэмжээний хараат бүс бие даасан, мэргэжлийн шинжээчдийн найдвартай мэдээлэл, дүгнэлтийг өгөх зорилготой бөгөөд дэлхийн нийт 50 улсын, 2000 гаруй дээд боловсролын шилдэг сургалтын байгууллагууд, 12000 гаруй ажил олгогч нартай хамтран ажилладаг. Тус байгууллага нь жил бүр дэлхийн шилдэг 500 сургууль, Азийн 300 их сургуулиудыг 6 шалгуур үзүүлэлтээр шалгаруулдаг Дэлхийн 800 гаруй их сургуулиудыг гүйцэтгэлийн 6 үндсэн ангиллаар үнэлж 2004 оноос эхлэн жил бүр эрэмбийг тогтоож байгаа болно. Анхнаасаа олон улсын түвшинд их сургуулийн эрэмбэ тогтоох зорилгоор бий болсон бөгөөд сүүлийн жилүүдэд олон оронд энэхүү системийн эрэмбийг өргөн хүрээтэй иш татан хэрэглэх болсон байна.

Хүснэгт 2: QS-ийн эрэмбэ тогтоох үзүүлэлтүүд

Ерөнхий үзүүлэлт	Тус бүрийн шалгуур үзүүлэлт	Үнэлэмж
Сургалтын нэр хүнд /Academic reputation	Олон улсын онлайн судалгааны үндсэн дээр	40%
Багшийн хүртээмжтэй байдал	Багш/Оюутны харьцаа	20%
Судалгааны нөлөөлөлийн байдал	Нэг багшид ногдох ишлэлийн тоо SCOPUS	20%
Ажил олгогчийн дундах нэр хүнд /Employer reputation	Олон улсын онлайн судалгааны үндсэн дээр /төгсөгчдөд ажил олгогчдоос/	10%
Гадаад оюутан	Гадаад оюутны хувийн жин	5%
Гадаад багш/ажилтнууд	Гадаад багш нарын хувийн жин	5%

Ерөнхийдөө “таймс дээд боловсрол”-ын системтэй нэлээд төстэй бөгөөд олон улсын түвшинд онлайн хэлбэрээр явуулдаг сургалтын нэр хүндийн тухай асуулгад нь дээд боловсролын салбарт ажилладаг 40 гаруй мянган хүн, ажил олгогчдын дундах нэр хүндийн судалгаанд нь 10 гаруй мянган ажил олгогчид жил бүр хамрагддаг байна. Энэхүү асуулгаас гарах мэдээлэл их сургуулийн эрэмбэ тогтоох үнэлгээний 50% орчмыг бүрдүүлдэг байна.

“U.S. News & World Report” – “АНУ-ын Мэдээ ба Дэлхийн мэдээлэл”

“АНУ-ын Мэдээ ба Дэлхийн Тайлан” нь АНУ-ын томоохон хэвлэлийн компани бөгөөд АНУ-ын ДСБС-ын эрэмбэлэлийг олон жилийн турш гаргаж мэдээлж ирсэн байна. Үүнээс үлбаалан одоогоор энэ байгууллага нь АНУ дахь хамгийн шилдэг боловсрол, анагаах ухаан, ажлын байр, аялал жуулчлал, машин зэрэг салбарт эрэмбэлэлийг гаргаж байна. Их сургуулиудын эрэмбэ тогтоохын хамт их сургуулийн бүрэлдэхүүний сургуулиуд, түүнчлэн хөтөлбөр тус бүрээр эрэмбэ тогтоодог нь их дээд сургуульд бакалавр, магистр, докторын түвшинд суралцахыг хүсэж оюутнуудад ихээхэн хэрэгтэй мэдээлэл болж өгдөг байна. Энэ системээр АНУ дахь хамгийн шилдэг ДСБС-ийг тодорхойлохдоо дараах хүснэгтэнд харуулсан 3 үндсэн шалгуур үзүүлэлтийг ашигладаг байна.

Хүснэгт 3: АНУ-ын Мэдээ ба Дэлхийн Тайлан системийн үзүүлэлтүүд

Ерөнхий үзүүлэлт	Нарийвчилсан шалгуур тус бүрийн үзүүлэлт	Үнэлэмж
Bibliometric үзүүлэлтүүд	Судалгааны бүтээл /Publications/	
	Ном	

	Эрдэм шинжилгээний хурал	65%
	Нормчилсон ишлэлийн нөлөө	
	Нийт ишлэлүүд	
	Хамгийн их иш татсан эхний 10 хувийн бүтээлд орсон хэвлүүлсэн бүтээлийн тоо	
	Нийт хэвлүүлсэн бүтээлийн хэдэн хувь нь хамгийн их иш татсан эхний 10 хувьд орсонийг илтгэх хувийн жин	
	Олон улсын хамтын ажиллагаа	
Сургуулийн түвшний үзүүлэлтүүд	Нийт Ph.D зэрэг олголтийн тоо	10%
	Тэнхим тус бүрийн Ph.D зэрэг олголтийн тоо	
Сургалтын нэр хүнд	Олон улсын онлайн судалгааны үндсэн дээр	25%
	Бүсийн судалгааны үндсэн дээр	

Энэхүү системээр их сургуулиудыг эрэмбэлэхдээ бусад системүүдийн адил онлайн судалгааны үр дүнг ашигладаг боловч энэ нь хаьцангуй бага хувийн жин 25% эзэлдэг байна. Бусад үзүүлэлтүүд нь бодитой, тухайн сургуулиас бараг хамааралгүйгээр гардаг үзүүлэлтүүд учир энэ эрэмбийг нэлээд найдвартай гэж үздэг байна. Харамсалтай нь энэхүү системд тэр болгон их сургууль хамрагдах боломж хязгаарлагдмал байгаа нь судалгааны цар хүрээ, үр нөлөө төдийлөн их биш, эрдэм шинжилгээний бүтээл нь тэр болгон АНУ-ын номын сангийн бүртгэлийн системд хамрагддаггүйтэй холбоотой байна.

“ARWU/Academic Ranking of World Universities” – “Дэлхийн Их Сургуулийн сургалтын эрэмбэ”

Дэлхийн их сургуулийн сургалтын эрэмбэ (ARWU), мөн Шанхайн эрэмбэлэл гэгддэг энэхүү эрэмбэ нь Хятадын Шанхай хотын эрэмбэлэлийн зөвлөлөөс гаргадаг хэвлэл юм. 2003 оноос эхлэн гаргаж байгаа Хятадын Шанхай хотын их сургуулийн нэгтгэдэг дэлхийн их сургуулиудын эрэмбэлэлийг олон талт үзүүлэлтүүд болон олон улсын зөвлөхүүдийн ТУЗ-ийн саналаар шийдвэрлэн нийтэлдэг байна.

Хүснэгт 4: Дэлхийн их сургуулийн сургалтын эрэмбэ тогтоох үзүүлэлтүүд

Ерөнхий үзүүлэлт	Тус бүрийн шалгуур үзүүлэлт	Үнэлэмж
Боловсролын чанар	Нобелийн шагнал болон бусад шагналт төгсөгч нарын тоогоор	10%
Багш нарын чанар	Нобелийн шагнал болон бусад шагналт багш нарын тоогоор	20%
	Ишлэл авсан тоо	20%

Судалгааны үр дүн	Шинжлэх ухаан ба байгаль орчны чиглэлээр гаргасан бүтээлүүд	20%
	Ишлэл авсан тоо	20%
Нэг хүнд ноогдох хүчин чадал	ДБСБ-ын нэг хүнд ноогдох хүчин чадал	10%

Өндөр хөгжилтэй оронд шилдэг их сургуульд бакалаврт сурахаар тэнцсэн монгол оюутанд төрөөс үнэ төлбөргүй сургах тухай журам үйлчилж байгаа. Энэ журамд дэлхийн шилдэг 20 болон 100 их сургуулийн тоонд тухайн сургууль орсон эсэхийг тодорхойлохдоо энэхүү системийн эрэмбийг авч үзэхээр тусгасан байна.

Их сургуулийн эрэмбэ тогтоох олон улсын системд хамрагдахад Монголын их дээд сургуулиудад тохиолдож буй бэрхшээлт асуудлууд

Монгол улсын ДБСБ-уудын эрэмбэ тогтоох арга зүйн асуудлуудын хувьд одоогоор ОУ-ын түвшингийн үзүүлэлтүүдийг хэрхэн нутагшуулах болон ямар тохиргоо хийх талаар судалгааны ажил хийгдэж байна. Бидний дүгнэлтээр Монгол улсын ДБСБ-ууд нь олон улсын эрэмбэлэлийн системд хамрагдах боломж бага байна. Энэ нь хэд хэдэн шалтгаантай юм. Дараах хүснэгтэнд хүндрэлтэй асуудал болон шийдвэрлэх арга замыг нэгтгэн харуулав.

Хүснэгт 5: Хүндрэлтэй асуудал болон шийдвэрлэх арга замууд

	ОУ-ын эрэмбэлэлд хамрагдахад тохиолдож буй хүндрэлтэй асуудал	Бармтлах бодлого, шийдвэрлэх арга зам	Тайлбар
1.	Олон улсын онлайн судалгаанд хамрагдаж чадахгүй байна	Монголоос олон олон хүмүүс нэр хүндийн судалгаанд оролцож бөглөх Гадаадын эрдэмтэд, ажил олгогчдын дунд Монголын ДБСБ-уудыг мэдүүлэх, танилцуулах	Онлайн асуулгыг олшруулж олон хүнд тараах арга хэмжээ БСШУЯ-тай хамтран авлаа.
2.	Судалгааны бүтээл хэвлүүлсэн байдал, нөлөөлөл, ишлэлтэй холбоотой үзүүлтүүдийг хангаж чадахгүй байна	Монголоос импакт фактор өндөртэй сэтгүүлүүдэд судалгааны өгүүлэл хэвлүүлэх явдлыг нэмэгдүүлэх Ишлэл авсан байдлын судалгаа хийх	Энэ асуудлаар тусгай бодлого боловсруулж хэрэгжүүлэх хэрэгтэй
3.	Даяарчилалтай холбоотой үзүүлэлтүүдийг хангаж чадахгүй	Гадаад оюутан суралцах бүх нөхцлийг бүрдүүлж гадаад оюутны тоог нэмэгдүүлэх системтэй арга хэмжээ авах Гадаад багш нарыг авч ажиллуулах талаар бодлого боловсруулж хэрэгжүүлэх	Гадаад оюутны амьдрах байр, гадаад хэл дээр хичээл үзэх боломж, гадагш чиглэсэн маркетингийг нэмэгдүүлэх хэрэгтэй. Гадаад

			багш нарын хувьд мөн адил бодлого хэрэгтэй
--	--	--	--

QS-ийн эрэмбэ тогтоох системийн мэргэжилтнүүдтэй холбоо тогтоож Монголд хэрэгжүүлж болох эрэмбэ болон чансаа тогтоох системийн талаар санал солилцох уулзалт хийсэн. Энэ уулзалтын дүнгээс ямар дүгнэлт гарч байна гэхээр Монголын томоохон их сургуулиуд нь олон салбар, чиглэл мэргэжлээр сургалт явуулдаггүй, ихэвчлэн цөөхөн салбарт төвлөрч төрөлжсөн учир тэр болгон олон улсад танигдаагүй, шууд олон улсын эрэмбэлэлд хамрагдах боломж хязгаарлагдмал байна. Ийм учраас эхний ээлжинд ДБСБ-ын чансаа тогтоох систем тухайлбал, “QS Star” үнэлгээний системийг нэвтрүүлж улмаар цаашдаа эрэмбийн системд хамрагдах нь зүйтэй юм.

Энэ байдлыг харгалзан QS Од үнэлгээний аргачлалыг бүрэн эхээр нь авч орчуулж Монголын дээд боловсролын байгууллагуудад түршилтийн журмаар үнэлгээ хийх бэлтгэлийг хангав. Энэ ажлын хүрээнд өөрийн үнэлгээний хуудсыг боловсруулж БСШУЯ-ны мэргэжилтэн Отгонбаттай хамтран 20 гаруй их сургуулиас 2016 оны 4-5 сард судалгаа авч, дүн шинжилгээ хийж үзсэн болно. Судалгааны дэлгэрэнгүй үр дүнг судалгаанд хамрагдсан сургуулиудын төлөөлөл нийтдээ 50 хүн оролцсон хэлэлцүүлгийг 2016 оны 5-р сард зохион байгуулж танилцуулсан болно. Энэ хэлэлцүүлгийн явцад чансаа тогтоох үзүүлэлтүүд нь манай орны нөхцөлд хэр зохистой байсан, үзүүлэлтүүдийг тооцоход хэр хүндрэлтэй байсан талаар оролцогчдын санал бодлыг авсан болно.

Судалгааны зарим үр дүнгээс товч байдлаар оруулах нь зүйтэй гэж үзлээ. Зураг 2-рт Монголын их сургуулиудыг QS Од-ын өөрийн үнэлгээний дагуу авсан нийт оноогоор нь жагсааж харуулав.

Зураг 2: Их сургуулиудын нэгдсэн оноо



Их сургуулиудын нийт авсан оноо нь 198 –аас 628 хүртэл байна. Эдгээр оноог гадаадын их сургуулиудын уг аргачлалаар оноо авч эрэмбэлэгдсэн байдалтай харьцуулахад 628 оноо авсан их сургууль Азийн шилдэг сургуулиудын дотор 107-д жагсаж байна. Тэгэхээр 628 авсан ШУТИС Азид 107 орох, хэрэв нэмж 4 оноо аваад нийт оноо нь 632 болсон бол Азид 100-д жагсах боломжтой нь харагдаж байна. 544 оноо авсан АШУУИС 133-д орох боломжтой болж байна. Эндээс үзэхэд Монголын их сургуулиуд Азийн их сургуулиудын дотор чансаагаараа эхний 100-д ороход ойрхон байна гэж үзэж болохоор байна. Зураг 3-д Монголын их сургуулиудын авсан нийт оноог үнэлгээний үзүүлэлтийн бүлэг бүрээр задалж харуулав. Эндээс үзэхэд Монголын их сургуулиуд үндсэн шалгуур үзүүлэлтүүд дээр харьцангуй гайгүй үнэлгээ авч байгаа боловч сургалтын орчин, тусгайлсан болон гүнзгийрүүлсэн шалгуурууд дээр ихэхэн сургууль авах ёстой онооны 50%-аас бага оноо авч байна.

Зураг 3: Их сургуулиудын нийт онооны задаргаа



Энэхүү судалгаа болон дээр дурьдсан хэлэлцүүлгийн үр дүнгээр “QS Од”-ийн аргачлалаар чансаа тогтооход Монголын их, дээд сургуулиуд дээр одоогоор тооцож болохгүй байгаа таван үзүүлэлтийг тодорхойллоо. Эдгээрийг Зураг 4-д харуулав. Санал асуулгын үр дүнгээр тодорхойлдог ажил олгогчдын дундах нэр хүнд, сургуулийн нэр хүнд, Scopus-д бүртгэгдсэн үйлдвэрлэлийн судалгааны тоо, олон улсын эрэмбэд эзэлсэн байр суурь болон Нобелийн шагналт эрдэмтдийн тоо зэрэг нь одоогоор монголын нөхцөлд хэрэглэж болохооргүй үзүүлэлт гэж үзэж байна. Их сургуулийн эрэмбэлэлийн санал асуулгад онолын хувьд хамрагдах боломжтой боловч практик дээр ийм судалгаа одоогоор үндэсний түвшинд ч явагдахгүй байгаа болно. Энд дурьдсан зарим нэг үзүүлэлтийг орлуулан дүйцүүлэх үзүүлэлтийг сонгож хэрэглэх боломж бас байна. Тухайлбал, Нобелийн шагналтны тооны оронд үндэсний хэмжээний шагналтнуудын тоог авч үзэж болох юм. Ойрын үед энэ аргачлалыг хэрэглэхдээ эдгээр үзүүлэлтийг хасаад тооцох боломж бас бүрэн байна гэж үзэж байна. Ингэхэд 280 оноо нийт онооноос хасагдах болж байна. Энэхүү үнэлгээний нийт дээд оноо 1000 байх ёстой учир нөөцийн 80 онооны нэг үзүүлэлт нэмээд ашиглах боломжтой юм. Үүнд

Бүтээлээрээ олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрдэмтдийн тоо 20 байх гэдгийг бүтээлээрээ үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн эрдэмтдийн тоо 20 байх гэж өөрчилж хэрэглэж болох юм.

Зураг 4: Тооцоход хүндрэлтэй үзүүлэлтүүд



Зураг 5, 6, болон 7-д энэхүү аргачлалыг тайлбарлан харуулав. Товчоор хэлэхэд “QS-Од” үнэлгээнд 4 бүлэг шалгуур үзүүлэлт хэрэглэгддэг бөгөөд үүнд үндсэн шалгуур, суралцах орчны шалгуур, тусгай шалгуур, гүнзгийрүүлсэн шалгуур орно. Үндсэн шалгуур нь багшлахуй, хөдөлмөр эрхлэлт, судалгаа шинжилгээ, даяаршсан байдал зэргийг хамарч байна. Үүний зэрэгцээ хичээлийн байр танхим, цахим сургалт, соёл, шинэ бүтээл, нийгмийн оролцоо, нээлттэй байдал, хичээлийн үнэлгээ, магадлан итгэмжлэл зэрэг үзүүлэлт бас бий.

Зураг 5: “QS-Од” үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд



Эдгээр бүх үзүүлэлтүүд нийлээд дээд тал нь 1200 оноо авах боломжтой боловч зөвхөн 1000 онооноос тооцож тухайн сургуульд олгох одын тоог тогтоодог байна. Үүнд: 700-аас дээш оноо авбал 5 од, 550-700 бол 4 од, 400-550 бол 3 од, 250-400 бол 2 од, 100-250 бол 1 од олгодог байна.

Зураг 6: “QS-Од” үнэлгээний онооны систем



Зураг 7: “QS-Од” үнэлгээний үзүүлэлтийн тоо

QS Од чансааны аргачлал



Шалгуур үзүүлэлтүүд - 47

600
ОНОО

Үндсэн шалгуур 18

- Багшлахуй 4
- Хөдөлмөр эрхлэлт 3
- Судалгаа шинжилгээ 4
- Даяаршсан байдал 7

200
ОНОО

Суралцах орчин 12

- Хичээлийн байр 6
- Онлайн ба зайн сургалт 6

200
ОНОО

Гүнзгийрүүлсэн шалгуур 15

- Соёл 3
- Шинэ бүтээл 3
- Нийгмийн оролцоо 4
- Нээлттэй байдал 5

200
ОНОО

Тусгайлсан шалгуур 2

- Хичээлийн үнэлгээ 1
- Магадлан итгэмжлэл 1

Нийт 47 үзүүлэлтээр 1200 оноог тооцож байгаа бөгөөд үүнээс 32 үзүүлэлт үндсэн дүгнэлт өгөх 1000 оноог бүрдүүлж байна.

Дээр дурьдсан 4 бүлэг шалгуур нь нийт 47 үзүүлэлт болж задардаг. Асуулга болон SCOPUS-ийн бүртгэлээр гардаг 4 үзүүлэлтийг тооцохгүйгээр энэ аргачлалыг хэрэглэх боломжтой гэж үзэж байна.

“QS-Од” үнэлгээний аргачлалыг суурь болгон дараах аргачлалыг Монголын ДБСБ-д нэвтрүүлэхээр санал болгож байна.

ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ЧАНСААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

Үнэлгээний дээд хязгаар болон чансааны үнэлгээний урьдчилсан нөхцлүүдийг дор харуулав.

Нийт оноо.....	1000
1 Од	100
• Өөрийн нэрээр боловсролын зохих зэрэг олгох хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрхтэй байх	
2 Од	250
3 Од	400
4 Од	550
• Ядаж 75 шүүмжлэгчтэй байх эсвэл нэг багшид ногдох ишлэлийн тоо 2 байх /багш нарын мэргэжлийн бүлгээр 2 болон түүнээс доош бүлэгт хамрагдахгүй сургуулийн тухайд/	
• Суралцаж байгаа гадаад оюутны тоо нь ядаж 1% байх	
5 Од	700

- Ядаж 150 шүүмжлэгчтэй байх эсвэл нэг багшид ногдох ишлэлийн тоо 3 байх /багш нарын мэргэжлийн бүлгээр 2 болон түүнээс доош бүлэгт хамрагдахгүй сургуулийн тухайд/
- Ажиллаж байгаа гадаад багш нарын тоо нь ядаж 5% байх
- Суралцаж байгаа гадаад оюутны тоо нь ядаж 5% байх
- Хөдөлмөр эрхлэлтийн талаар ядаж 85 оноо авсан байх
- Хичээлийн байр танхимийн талаар дор хаяж 70 оноо авсан байх

5 Од нэмэх900

❖ Үнэлгээний бүр үзүүлэлтээр 5 од авч, 5 одны бүх урьдчилсан нөхцлийг хангасан байх.

Одуудад харгалзах оноог үнэлгээний үзүүлэлт бүрээр хэрхэн хуваарилагдсаныг дор үзүүлэв.

Үндсэн шалгуур үзүүлэлт150	Тусгайлсан шалгуур үзүүлэлт200
1 од15	1 од20
2 од35	2 од50
3 од60	3 од80
4 од85	4 од110
5 од105	5 од140

Суралцах орчны үзүүлэлт100	Гүнзгийрүүлсэн шалгуур үзүүлэлт 50
1 од10	1 од5
2 од25	2 од15
3 од40	3 од20
4 од55	4 од30
5 од70	5 од35

ҮНДСЭН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Энэ бүлгийн үзүүлэлтүүд нь олон улс, тухайн нэг улс, орон нутаг гэх мэт үйлчилгээний хүрээг үл харгалзан аливаа их сургуулийн үндсэн суурь бүтэц бүрэлдэхүүнийг илэрхийлнэ. Үнэлгээнд энэ бүлгийн бүх үзүүлэлтийг заавал ашиглана.

Багшлахуй	150
-----------	-----

❖ Оюутан багшийн тооны харьцаа 50

10:1 гэсэн харьцаанд ногдох дээд оноо /10%/ нь бүүрсаар 50:1 харьцаанд /2%/ ногдох доод оноо болно

❖ Оюутны сэтгэл ханамж, эсвэл төгсөлтийн хувь40

Оюутны сэтгэл ханамж

Төгсөлтийн хувь

Нийт оюутны сэтгэл ханамж 50% -аас 75% хооронд байх. Энэ нь нийт оюутны 20%-ийг эсвэл 1000 оюутныг хамарсан оюутны сэтгэл ханамжийн үндэсний судалгаа буюу

Төгсөх курсийн оюутны төгсөлтийн хувь 60%-90% хооронд байх. 90% болон дээш бол дээд оноо, 60% бол доод оноо өгнө.

түүнтэй адилтгах судалгаанд үндэслэсэн байна.

❖ Хичээл заалтын сэтгэл ханамж, эсвэл докторын зэрэгтэй багшийн хувь40

<i>Оюутны сэтгэл ханамж</i> <i>Нийт оюутны хичээл заалтанд сэтгэл ханамжтай байх хувь 50% -аас 75% хооронд байх. Энэ нь нийт оюутны 20%-ийг эсвэл 1000 оюутныг хамарсан оюутны сэтгэл ханамжийн үндэсний судалгаа буюу түүнтэй адилтгах судалгаанд үндэслэсэн байна.</i>	<i>Докторын зэрэгтэй багшийн хувь</i> <i>Докторын зэрэгтэй багшийн эзлэх хувь 60%-80% хооронд байх. 80% болон дээш бол дээд оноо, 60% бол доод оноо өгнө.</i>
--	---

❖ Үргэлжлүүлэн суралцах20

Төгссөнөөс хойших 12 сарын дотор цаашид үргэлжлүүлэн суралцаж буй оюутны хувь 10-30% хооронд байх.

Хөдөлмөр эрхлэлт 150

❖ Төгсөгчдийн ажил эрхлэлтийн хувь50

Үргэлжлүүлэн суралцаж буй оюутныг оролцуулахгүйгээр төгссөнөөс хойших 12 сарын дотор ажилд орсон оюутны хувийн жин 50-90% байна. 50% бол доод оноо, 90% бол дээд оноо өгнө.

❖ Ажил мэргэжлийн зөвлөгөө, дэмжлэг50

Ажил мэргэжлийн зөвлөлгөө өгөх орон тооны ажилтны тоо 2 –оос 10 хүртэл байх, эсвэл 1000 оюутан бүрт 1 орон тооны ажилтантай байх, эсвэл ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх албанд 25 орон тооны ажилтан ажиллах.

Судалгаа хөгжил 150

❖ Нэг багшид ногдох судалгааны, эсвэл урлагийн бүтээл40

<i>Нэг багшид ногдох судалгааны бүтээл</i> <i>Нэг багшид ногдох судалгааны бүтээлийн тоо 7 байна /Scopus –т бүртгэгдсэнээр/</i>	<i>Багшийн урлаг, уран сайханы бүтээл</i> <i>Сэтгүүлд нийтлүүлсэн судалгааны бүтээлээр хэмжиж болохгүй салбарын багш нарын бүтээлийг хүлээн зөвшөөрөх</i>
---	---

❖ Бүтээлээс авсан эшлэлийн тоо40

Нэг бүтээлээс авсан эшлэлийн тоо 6 байх /Энэ тоог анагаах ухаан, шинжлэх ухаан, технологийн салбарт сургалт явуулдаггүй сургуульд багасгаж хэрэглэнэ./

❖ Нэр хүндтэй эрдэмтэн, мэргэжилтэн30

Хийсэн ажил, бүтээлээрээ үндэсний хэмжээнд/олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрдэмтдийн тоо 20 байх

Даяаршсан байдал
150

- ❖ Олон улсын багш нар20

Гадаад багш нарын эзлэх хувь 25% байх

- ❖ Олон улсын хамтын ажиллагаа40

Өмнөх 3 жилд КьюЭс дэлхийн их сургуулийн зэрэглэлийн эхний 500-д багтсан их сургуулиудтай судалгааны хамтын ажиллагаа хэрэгжүүлдэг, эсвэл хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлдэг.

- ❖ Гадаад оюутан20

Гадаад оюутны эзлэх хувь 20% байх

- ❖ Шашны мөргөлийн байр10

Шашны /христийн, исламын, хиндийн, буддын, тао, иудийн гэх мэт/ мөргөлийн 3 байртай байх, эсвэл олон шашинд зориулсан байртай байх.

- ❖ Гадаад оюутан солилцоо20

Нийт оюутны тооны 2%-тай тэнцэх гадаад оюутан хүлээн авдаг байх

- ❖ Өөрийн оюутан солилцоо20

Нийт оюутны тооны 2%-тай тэнцэх оюутан гадаадад солилцоогоор явуулдаг байх

- ❖ Олон улсын олон янз байдал10

Оюутны дотор 5-аас 50 орны төлөөлөл байх

СУРАЛЦАХ ОРЧИН

Их сургууль гэдэг бол зөвхөн сургалт, судалгаа биш юм. Дор дурьдсан шалгуур үзүүлэлтүүд нь их сургуулийн оюутны амьдралын төв болсон суралцах орчныг сайжруулах чухал хэсгүүдийг хамардаг. Сургуулиуд нь дараах 2 төрлийн суралцах орчны аль нэгийг сонгодог.

Хичээлийн байр танхим

100

- ❖ Хичээллэх анги танхим, лабораторийн хүрэлцээ.....10
- ❖ Спортын байр, танхим10

Кампусын дотор байгаа дараах байр танхим бүрт 2 оноо өгөх бөгөөд 6-аас дээш байр танхимтай бол шагналын 4 оноо нэмж өгнө. Үүнд:

1. Усан сан/Бассейн
2. Фитнесийн байр/бялдаржуулах төв

3. Доторх спорт заалууд
 4. Спортын янз бүрийн төрлүүдэд зориулсан ил талбайнууд
 5. Спортын зориулалттай задгай талбай
 6. Гүйлтийн зам
 7. Стадион
 8. Орон тооны спортын дасгалжуулагч болон спортын эрүүл мэндийн ажилтан
- ❖ Эмнэлгийн байр танхим10

Орон тооны их эмч бүхий эрүүл мэндийн төв буюу 3000 оюутан тутам нэг орон тооны сувилагч

- ❖ Оюутны нийгэмлэг, холбоод10

Оюутны удирдлагатай байгуулалгын тоо 10- аас 50 байх

- ❖ Оюутны байр20

Оюутны байрны өрөөний тоо нь нэгдүгээр күрсийн оюутны тоотой тэнцүү байвал дээд оноог өгнө.

- ❖ МХТ-ийн дэд бүтэц, програм хангамж.....20

5 оюутан тутамд 1 суурин компьютер ногдох, эсвэл сургуулийн оюутны бүх байр интернеттэй байх, эсвэл спортын талбай, машины паркийн талбайг оролцуулахгүйгээр кампусийн нийт орчны 60-90% -д нь WIFI холболттой байх

- ❖ Номын сан20

Өнгөрсөн жилд номын санд оруулсан хөрөнгө оруулалт нь нэг оюутанд ногдох байдлаар \$10 - \$250 байх, эсвэл нэг оюутанд ногдох номын сангийн номны нэрийн тоо 1-3 байх

**Онлайн болон зайн сургалт
100**

- ❖ Сүүлийн үеийн технологи20

Хөтөлбөр хэрэгжүүлэхэд хамгийн шинэ технологи хэрэглэх

- ❖ Онлайн сургалтын түршлага10

Онлайн сургалтын хөтөлбөр амжилттай хэрэгжүүлж ирсэн хугацаа

- ❖ Оюутан багшийн харилцаа20

Багштай биечлэн уулзаж зөвлөлгөө авах боломжоор хангагдсан байх

- ❖ Оюутны харилцаа20

Бусад оюутнуудтай харилцах боломжтой байх

❖ Онлайн сургалтанд тавих анхаарал10

Онлайн хэлбэрээр хэрэгжүүлж буй хөтөлбөрийн тоо/хувийн жин

❖ Нэр хүнд20

Онлайн хөтөлбөр болон технологийг ажилчдаа сургахад хэрэглэсэн байгуулалгын тоо

ТУСГАЙЛСАН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Тусгайлсан нэг явцуу хүрээнд жишиг болохуйц ур чадвар бүрдүүлэх нь дэлхийн түвшинд хүрсэн гэж үзэх нэг үндэс болно. Энэ бүлгийн шалгуур үзүүлэлтүүд нь үнэхээр сайн зүйлсэд зохих оноо үнэлгээг нь өгөх зорилготой. Үнэлгээнд энэ бүлгийн бүх үзүүлэлтийг заавал хамруулна.

Хичээлийн үнэлгээ

150

❖ Багш нарын салбарын үнэлгээ, эсвэл тусгай хичээлийн зэрэглэл150

Багш нарын салбарын үнэлгээ

Багшийн салбарын үнэлгээгээр тогтоосон КьюЭс их сургуулийн зэрэглэлд дээгүүр байр эзэлсэн байх. 1-ээс 50 –р байранд орсон бол дээд оноо, 300-р байранд доод оноо өгнө.

Тусгай хичээлийн зэрэглэл

Тусгай хичээлийн үнэлгээгээр тогтоосон КьюЭс их сургуулийн зэрэглэлд дээгүүр байр эзэлсэн байх. 1-ээс 20 –р байранд орсон бол дээд оноо, 200-р байранд доод 10 оноо өгнө.

1. Инженер, технологийн салбар
2. Байгалийн ухааны салбар
3. Амьдралын ухаан, анагаах ухаан
4. Урлаг, хүмүүнлэгийн салбар
5. Нийгмийн ухаан, удирдлага

Магадлан итгэмжлэл

50

❖ Олон улсын болон/эсвэл үндэсний хэмжээний магадлан итгэмжлэл50

Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн магадлан итгэмжлэлд 25 оноо, үндэсний магадлан итгэмжлэлд 10 оноо гэх мэтээр 50 хүртэл оноо өгнө.

ГҮНЗГИЙРҮҮЛСЭН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Дэлхийн түвшний их сургууль байхын тулд түүний эрхэм зорилго, үзүүлэх үр нөлөө нь зөвхөн үндсэн үзүүлэлтээр илэрхийлэгдэж болохгүй. Энэ хэсэг багтсан үзүүлэлтүүд нь үндсэн шалгуур үзүүлэлтээр өндөр үнэлгээ авсан сургуулиуд илүү дээд түвшинд үйл ажиллагаа явуулах, хүлээн зөвшөөрөгдөхөд харгалзвал зохих чухал хүчин зүйлүүдийг тусгасан болно.

Төрөлжилт нь харилцан адилгүй байх учир их сургуулиуд өөрийнх нь давуу талыг илүү харуулж чадах 2 хэсэг үзүүлэлтийг энэ бүлгээс сонгож үнэлгээнд хамруулж болно.

Соёл	50
-------------	-----------

- ❖ Концерт болон уран бүтээлийн үзэсгэлэн20

Багш, оюутны бүтээсэн 300-аас 500 концерт, үзэсгэлэнд зохи оноог өгнө.

- ❖ Соёлын шагнал, магтаал20

Нийтийн үзэж сонирхож болох сургуулийн, багш нарын, оюутны ажил, бүтээлд хүртсэн шагнал, гэрчилгээ 60-аас 100 байвал зохих оноог өгнө.

- ❖ Соёлын хөрөнгө оруулалт10

Сургуулиас гадуурх урлаг, соёлын төсөлд нийт орлогын 1%-тай тэнцэх, эсвэл 2 сая ам долларын хөрөнгө зарцуулсан байх. Эсвэл соёлын өвийг хамгаалахад хөрөнгө оруулсан байх.

Шинэ бүтээл	50
--------------------	-----------

- ❖ Патент20

Үндэсний болон олон улсын патентийн газарт бүртгүүлсэн 50 идэвхтэй патенттай байх

- ❖ Гарааны компаниуд20

Сүүлийн 5 жилд сургууль дээр багйуулагдаж одоо бие даан үйл ажиллагаа явуулж буй дор хаяж 5 компанитай байх.

Нийгмийн оролцоо	50
-------------------------	-----------

- ❖ Орон нутгийн хөгжил, хөрөнгө оруулалт20

Сургуулийн эргэн тойрон 200 км доторх орон нутгийн төсөлд нийт орлогын 1%-тай тэнцэх, эсвэл 2 сая ам долларын хөрөнгө зарцуулсан байх.

- ❖ Сайн санааны түслэмж, гамшгаас хамгаалах үйл ажиллагаа10

Нийт орлогын 1%-тай тэнцэх, эсвэл 2 сая ам долларын хөрөнгө олон улсын болон үндэсний хэмжээний байгалийн гамшигийг даван туулах, эсвэл сайн санааны үйлст зориулсан байх.

- ❖ Бүс нутгийн хүмүүн капиталын хөгжил10

Төгсөгчдийн 30-аас 50% нь бүс нутагтаа ажиллаж амьдрах, эсвэл бүс нутгаас суралцагчдын тоо 30-аас 50% байх.

- ❖ Байгаль орчин үзүүлэх нөлөө10

Дараах зүл тус бүрт 2 оноо өгнө. Үүнд:

1. Тогтвортой хөгжлийн вебсайт ажиллуулах
2. Эрчим хүч хэмнэх хөтөлбөр хэрэгжүүлдэг
3. Ус хэмнэх хөтөлбөр хэрэгжүүлдэг
4. Хог хаягдал эргүүлэн ашиглах хөтөлбөр хэрэгжүүлдэг
5. Тээврийн бодлого хэрэгжүүлдэг

Нээлттэй байдал
50

❖ Тэтгэлэг, стипенд20

Нийт орлогын 2%-тай тэнцэх хөрөнгийг оюутны тэтгэлэгт зориулсан байх, эсвэл 200 оюутанд 50%-ийн хөнгөлөлт үзүүлж суралцах боломж олгосон байх.

❖ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нэвтрэх боломж олгох10

Түрдэг дугуйтай иргэд орох боломжийг кампусийн нийт орцийн 40-өөс 80% нь хангасан байх

❖ Хүйсийн тэнцвэрт харьцаа10

60:40 –өөс 50:50 хооронд байх.

❖ Орлого багатай иргэдэд сурах боломж олгох10

Орлого багатай гэр бүлээс суралцаж буй оюутнууд 5-15% байх, эсвэл нийт орлогын 1%-тай тэнцэх хөрөнгө буюу 2 сая ам долларыг орлого багатай оюутнийг дэмжихэд зориулсан байх.

Энэхүү аргачлалыг ашиглан их, дээд сургуулиуд өөрсдийн бодит мэдээлэлд үндэслэн чансааны үнэлгээ хийж хэвших нь зүйтэй юм.

Санал, зөвлөмж

1. Их сургуулийн эрэмбэлэлийн олон улсын системд хамрагдах зорилгоор монголын их сургуулиуд дээр дор дурьдсан чиглэл тус бүрээр тодорхой төлөвлөгөө гаргаж системтэй арга хэмжээ авах хэрэгтэй байна. Үүнд:
 - а. Судалгаа асуулганд аль болох олон хүнийг татан оролцуулж судалгааг бөглүүлэх, энэ зорилгоор ялангуяа төгсөгчдийг татан оролцуулахын тулд зохих урамшууллын хөшүүрэг хэрэглэх
 - б. Гадаадын эрдэмтэд, ажил олгогчдын дунд Монголын ДБСБ-уудыг мэдүүлэх, танилцуулах

- c. Монголоос импакт фактор өндөртэй эрдэм шинжилгээний сэтгүүлүүдэд судалгааны өгүүлэл, бүтээл хэвлүүлэх явдлыг нэмэгдүүлэх, санхүүгийн дэмжлэг санал болгох
 - d. Монголын эрдэмтдийн бүтээлээс олон улсад эшлэл авсан байдлын судалгаа хийх
 - e. Гадаад оюутан суралцах бүх нөхцлийг бүрдүүлж гадаад оюутны тоог нэмэгдүүлэх системтэй арга хэмжээ авах
 - f. Гадаад багш нарыг авч ажиллуулах талаар бодлого боловсруулж хэрэгжүүлэх
- 2. Үндэсний хэмжээнд их, дээд сургуулийн эрэмбэ тогтоох судалгааг 2016-2017 оны хичээлийн жилд багтаан зохион байгуулах. Үүний тулд 2008 онд анх удаа БСШУЯ-ны Мэргэжлийн боловсролын газраас зохион байгуулсан “Дээд сургуулиудыг шинжихүй” судалгааг давтан хийх нь зүйтэй гэж үзэж байна. Энэ судалгаа нь
 - a. Дээд боловсролын сургалтын байгууллагын захирлууд, боловсролын шинжээч судлаачид, өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгслийн нийгмийн болон боловсролын бодлогын асуудлаар дагнан ажиллаж байгаа сэтгүүлчид, ажилтнууд, ажил олгогчидаас асуулга авах
 - b. Асуулгад сургалтын чанар, сургалтын материаллаг бааз, оюутанд үзүүлдэг үйлчилгээ, дэмжлэг гэсэн 3 хэсэг асуудлыг тусгаж оруулах
 - c. Асуулгад хамрагдах боломжтой зорилтот бүлгийн тоо, хүмүүсийн жагсаалтыг гаргаж түүнээс санамсаргүй сонголтын аргаар түүвэр сонгох
 - d. Төрийн өмчийн, хувийн болон төрийн бус бүх их сургууль, дээд сургууль, коллежүүдийн талаар асуулгын судалгааг зохион байгуулах
 - e. Үр дүнг боловсруулж 2008 онд гарсан үр дүнтэй харьцуулах хэрэгтэй байна.
- 3. Монголын ДБСБ-ын эрэмбэ тогтоох судалгаа хийхийн зэрэгцээ дээр санал болгож буй аргачлалыг ашиглан чансаа тогтоох системийг хэрэгжүүлж эхлэх
- 4. Энэ ажлыг, мөн дээр дурьдсан эрэмбэ тогтоох судалгааг Дээд боловсролын шинэчлэлийн төслийн ажлын төлөвлөгөөнд тусгаж санхүүжүүлэн хэрэгжүүлэх
- 5. Цаашдаа эрэмбэ тогтоох судалгаа, чансаа тогтоох судалгааг аль болох хөндлөнгийн, хараат бус байгууллагаар гүйцэтгүүлж байх нь зүйтэй юм. Энэ ажлыг жишээ нь Их дээд сургуулиудын консорциум гүйцэтгэж болно. Гэхдээ эхний ээлжинд Боловсролын Магадлан Итгэмжлэлийн Үндэсний Зөвлөлийн ажлын аппаратад шинээр нэг нэгж бий болгож энэ асуудлыг хариуцуулах нь зүйтэй гэсэн саналтай байна.
- 6. БМИҮЗ-ийн бүрэлдэхүүнд шинээр байгуулах нэгжийн ажилтнуудад эрэмбэ болон чансаа тогтоох арга зүйн асуудлаар сургалт явуулах нь зүйтэй юм. Үүнд үндэсний зөвлөхүүд болон энэ асуудлаар сонирхон судалж, мэргэшиж буй хүмүүсийг ашиглах хэргэтэй юм.
- 7. Дээд боловсролын шинэчлэлийн төслийн хүрээнд эрэмбэ болон чансаа тогтоох асуудлаар гадаадад судалгааны аялал зохион байгуулах нь зүйтэй байна.